



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 6/536

Улаанбаатар хот

М.Ууганцэцэгийг албан тушаалд
томилох тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.3, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, 77.7.9, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам"-ын 2.1, Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 52 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцэж, нэр дэвшсэн Мөнхбатын Ууганцэцэгийг 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс арван хоёр сарын туршилтын хугацаагаар Дундговь аймгийн татварын хэлтсийн Захиргаа, хуулийн тасгийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэний албан тушаалд томилсугай.

2. Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн М.Ууганцэцэгийн туршилтын хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан, сар бүр үнэлж дүгнэх, ёс зүй, сахилга хариуцлагын байдалд хяналт тавих, албан тушаалын цалин, нэмэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож олгохыг Дундговь аймгийн татварын хэлтэс (М.Туяацэцэг)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Л.Нэргүй)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЗАЯАБАЛ

151611531